

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн

Төрийн зарим байгууллагууд

Дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Нэгдүгээр газар

Газрын
захирал: Ц.Батбаяр

Аудитын
менежер: Ж.Батсайхан

Ахлах
аудитор: Л.Одгэрэл

Аудитор: Б.Даваабаатар
З.Ариунзаяа

Шинжээч Л.Эрдэнэчулуун

Товчилсон үгийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	5

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын нэгтгэн зангидагдсан хэтийн бодлого, төлөвлөлт хангалтгүй байна

1.1. ТЕЗ-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг шаардлага хангахуйц бүрэн хэмжээнд төлөвлөхгүй байна	7
1.2. Хөрөнгө оруулалтын талаар улсын хэмжээнд нэгдсэн бодлого, төлөвлөлт дутагдалтайгаас санхүүгийн боломжийн хэмжээнд хүртээх байдлаар төлөвлөж байна	9
1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн байна	10

Бүлэг 2

Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байна

Оршил

2.1. Тендер зарлах хүртэлх бэлтгэл үе шатны ажлыг зохих хууль журмын дагуу хийхгүй байна	11
2.2. Гүйцэтгэгч шалгаруулах ажиллагаанд үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримталсан гэх үндэслэл муутай байна	12
2.3. ХАА-ны тайланг хугацаанд нь бүрэн тайлагнахгүй байна	13

Бүлэг 3

Гэрээ зөрчсөн, биелүүлээгүй, бараа, ажил, үйлчилгээг хугацаандаа нийлүүлээгүй гүйцэтгэгч байгууллагуудад алданги болон хариуцлага тооцохгүй байна

3.1. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах үйл явцтай холбоотой эрх зүйн орчинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна	15
---	----

2009 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

3.2. Гэрээний гүйцэтгэлд ач холбогдол өгөхгүй байна 15

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын гэрээний биелэлтэд хариуцлага тооцохгүй байна. . 16

Бүлэг 4

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны удирдлага, төлөвлөлт, санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо оновчтой, үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулагдаж чадахгүй байна

Оршил

4.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үйл ажиллагааг өөрчлөх шаардлагатай болжээ 17

4.2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт оновчтой бус байна 20

4.3. Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцад тавих дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна 21

Аудитын дүгнэлт 25

Аудитын зөвлөмж 26

Холбогдох байгууллагын санал:

Сангийн яамнаас ирүүлсэн санал

Бусад төрийн байгууллагын санал

Саналд өгсөн тайлбар

Хавсралт-1

Хавсралт-2

Судалгаа 1-3

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНАГ	<i>Аймаг, нийслэлийн аудитын газар</i>
БЗА	<i>Барилга захиалагчийн алба</i>
БТБС	<i>Бусад төрийн байгууллагын салбар</i>
ГХЯ	<i>Гадаад хэргийн яам</i>
ДБУААГ	<i>Дипломат байгууллагуудын үйлчилгээ, аж ахуйн газар</i>
ДНБ	<i>Дотоодын нийт бүтээгдэхүүн</i>
ЗГ	<i>Засгийн газар</i>
ЗГХЭГ	<i>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</i>
ИТЦ	<i>Их тэнгэр цогцолбор</i>
МУХС	<i>Монгол Улсыг хөгжүүлэх сан</i>
МШХХТГ	<i>Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар</i>
НТШ	<i>Нээлттэй тендер шалгаруулалт</i>
ОБЕГ	<i>Онцгой байдлын ерөнхий газар</i>
СЯ	<i>Сангийн яам</i>
СЕХ	<i>Сонгуулийн ерөнхий хороо</i>
ТАЭТЗТБ	<i>Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</i>
ТЕЗ	<i>Төсвийн ерөнхийлөн захирагч</i>
ТЕГ	<i>Тагнуулын ерөнхий газар</i>
ТБОНӨХБАҮХАТХ	<i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль</i>
ТБОНӨТХ	<i>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль</i>
ТБУСТХ	<i>Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль</i>
ТЗҮААЭГ	<i>Төр засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар</i>
ТӨӨЗ	<i>Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа</i>
ТӨХ	<i>Төрийн өмчийн хороо</i>
ТТХГ	<i>Төрийн тусгай хамгаалалтын газар</i>
ТХОХ	<i>Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтэс</i>
ТШӨХ	<i>Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт</i>
ТЭЗҮ	<i>Техник, эдийн засгийн үндэслэл</i>
УГЕГ	<i>Улсын гаалийн ерөнхий газар</i>
УИХ	<i>Улсын Их Хурал</i>
УМХГ	<i>Улсын мэргэжлийн хяналтын газар</i>
УТЕГ	<i>Улсын татварын ерөнхий газар</i>
ХААБГ	<i>Худалдан авах ажиллагааны бодлогын газар</i>
ХТШ	<i>Хязгаарлагдмал тендер шалгаруулалт</i>
ЦАУЗБУК	<i>Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс</i>
ЦЭК	<i>Цөмийн энергийн комисс</i>
ЧБ	<i>Чөлөөт бүс</i>
ЭСЯ	<i>Элчин сайдын яам</i>

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын төсөв, МУХС, урсгал санхүүжилт, хандив, зээл тусламжийн хөрөнгөөр 2008 онд төрийн зарим байгууллагуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аудит хийв.

Аудитын зорилт

Энэхүү аудитын зорилт нь бүх эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, түүний үндэслэл, үр нөлөө
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох ажиллагаа, түүний зохион байгуулалт, үр нөлөө
- Захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох үйл явцын хэрэгжилт, түүний үр нөлөө
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагааны удирдлага, санхүүжилтийн тогтолцоо оновчтой, үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад УИХ-ын Тамгын газар, Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд, Шадар сайдын багц, ҮХЦ, ЗГХЭГ, ТЕГ, ТТХГ, Цөмийн энергийн комисс, Оюуны өмчийн газар, ТӨХ, МШХХТГ, “Замын-Үүд”, “Алтанбулаг”, “Цагааннуур” “Чойр” чөлөөт бүс, ОБЕГ, УМХГ, ГХЯ, ДБУААГ, СЯ, УГЕГ, УТЕГ хамрагдлаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараахь арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын бодлого, төсвийн хүрээний мэдэгдэл, төлөвлөлтийн тооцооллын талаар аудитад хамрагдсан байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийж, тэднээс лавлагаа, тодруулга авах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгосон ажиллагааны талаархи материалыг аудитад хамрагдсан байгууллага бүрээр түүвэрлэн авч танилцах, ажил хариуцсан албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах;

- Захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлийг аудитад хамрагдсан байгууллагуудаас түүвэрлэн авч биет байдалтай нь тулган баталгаажуулах, гэрээг хугацаанд биелүүлээгүй шалтгаан, хариуцлага тооцсон эсэхийг захиалагч, гүйцэтгэгч нараас асууж, тодруулах;
- СЯ, захиалагчаас гүйцэтгэгчид санхүүжүүлсэн дүнг төсөл, арга хэмжээ бүрээр гэрээний дүн болон хөрөнгө оруулалтын тайлантай тулган баталгаажуулах, СЯ-ны хөрөнгө оруулалтын хэлтсээс санхүүжилтийн эрх нээсэн дүн, огноог зарим байгууллагад СЯ-наас санхүүжүүлсэн дүн, огноотой тулгах, БЗА-ыг байгуулсан эрх зүйн баримт бичигтэй танилцан БЗА-ны санхүүгийн үйл ажиллагааг баримтаар тулган баталгаажуулж шалгах, санхүүгийн тайланд тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулгын тайлантай тулгах, урсгал төсвийн хөрөнгөнөөс урсгал засварт зарцуулсан хөрөнгө болон худалдан авсан үндсэн хөрөнгийг тайлагналтай тулгах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцсон эсэх, хяналтыг явуулсан эсэхийг ажил хариуцсан албан тушаалтнуудаас асууж тодруулах;
- “IDEA-7.2” програм ашиглан Төрийн сангийн улсын төсөв, МУХС-гийн харилцах дансны гүйлгээг ТЕЗ болон төрийн бусад байгууллага бүрээр түүвэрлэн тухайн байгууллагын харилцах дансны гүйлгээтэй тулган баталгаажуулалт хийх, захиалагчаас гүйцэтгэгчдэд олгосон санхүүжилтийг гэрээний дүнтэй тулгах, төсөвт байгууллагаас хөрөнгө оруулалтын эрх нээлгэхээр хүссэн огноо, СЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн эрх нээсэн огноо, Төрийн сангийн газраас санхүүжүүлсэн огноо, захиалагчаас гүйцэтгэгчид олгосон огноог Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.14, 3.15 дугаар заалтын дагуу тулгах.

Аудитын явцад шалгах хуудсыг ашигласан ба аудит эхлэхээс өмнө СЯ, бусад ТЕЗ-даас хөрөнгө оруулалтын талаар гаргуулан авсан судалгааг тулган баталгаажуулсан.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгаа, фото болон хөдөлгөөнт зургийг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын нэгтгэн зангидагдсан хэтийн бодлого, төлөвлөлт хангалтгүй байна

1.1. ТЭЗ-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг шаардлага хангахуйц бүрэн хэмжээнд төлөвлөхгүй байна

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг бэлтгэж холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтны санал, дүгнэлтийг тусгуулж, баримтжуулж, баталгаажуулж байгаа байдлыг шалгахад дараахь зөрчил, дутагдал илэрлээ. Тухайлбал:

- ДБҮААГ-ын 2008 оны төсвийн хүрээний мэдээдлийг боловсруулахдаа төсөл, арга хэмжээний нарийвчилсан зураг, төслийг гаргаж өгөөгүй байна.
- ГХЯ-ны санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс ГХЯ, Дипломат төлөөлөгчийн газрын 2008 оны хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийн зураг төсөв, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг дутуу тусгасан төлөвлөгөө байна. ЭСЯ-ын байрны барилга барих, худалдан авах үнийн санал, автомашин болон тоног төхөөрөмж худалдан авах үнийн саналын судалгааг ЭСЯ-даас дутуу бүрдүүлэн авч хөрөнгө оруулалтын төсвийн тооцоог хангалтгүй хянаж байна. Зураг төсөв нь бэлэн бус төсөл арга хэмжээнд хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн байна. /Хавсралт 1-ийг үзнэ үү/
- ТЕГ-ын 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдээдэл алга байна. Хариуцаж байсан ажилтан ажлаас гарсан тул төсвийн төслийг хуулийн хугацаанд Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлсэн эсэх, төсвийн хүрээний мэдээдлийг байгууллагын удирдлагаар хэлэлцэж батласан эсэхийг нотлох баримт алга байна.
- ТЗҮААЭГ 2008 оны хөрөнгө оруулалтын төсвийн хүрээний мэдээдэлд их засварын төсвийн төсөв, зураг, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг дутуу тусгасан байлаа. /Хавсралт 1-ийг үзнэ үү/

УИХ-аар хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах явцад зураг, төсвийн тооцоо хийгээгүй төсөл, арга хэмжээнүүд орж ирдэг байна. Энэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн бодлогыг алдагдуулж байна. Тухайлбал: МШХХТГ-ын “4 сувгийн телевизийн дамжуулах шугам, радиогийн дахин дамжуулах станц байгуулах” ажилд нийт 126.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлуулжээ.

2008 оны Монгол улсын Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 76.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 49.5 тэрбум төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүхий 216 барилга байгууламж зураг төсөвгүйгээр тусгагджээ. Хөрөнгө оруулалтын нийт эх үүсвэрийн 8.7 хувь нь зураг төсөвгүй объектуудад төсөвлөгдсөн байна. /Хавсралт 2-ыг үзнэ үү/

Үүний дотор УИХ-аар хэлэлцэж батлах явцад зураг, төсөвгүй 15.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий объектод 2008 онд 12.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тусгасан байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд УИХ-ын гишүүдийн зүгээс тусгуулсан зураг, төсөвгүй төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар үзүүлэв. /Хавсралт 2-ыг үзнэ үү/

ТТХГ, МОНЦАМЭ, ГХЯ, ЗГХЭГ хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр боловсруулж СЯ-ны ТБЗГ-ын төсвийн хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэхдээ ач холбогдлоор нь эрэмблэлгүй хөрөнгө оруулалтын жагсаалт оруулжээ. Тухайлбал: Зарим сумдын ЗДТГ-ын конторуудын барилга, их засварууд, Завхан, Дорнод аймгийн ЗДТГ-ын барилгуудын зураг төсвийн тооцоог хангалтгүй, дутуу хийснээс одоо хүртэл ашиглалтанд ороогүй байна.

Говьсүмбэр аймагт ЗГХЭГ-ын даргын багц дахь улсын төсвөөс 75.0 сая төгрөг, орон нутгийн дэмжлэгээр 95.0 сая төгрөг, нийт 170.0 сая төгрөг батлагдсан ч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулахдаа мэргэжлийн байгууллагаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, тооцооллыг хийлгээгүй байна.

Аудитад хамрагдсан ТЕЗ-д төсөвт өртгийг тооцож байгаа ч төсөвт өртөг нь хэр үндэслэлтэй, үнэн зөв тооцсон эсэхийг хянах тогтолцоо хангалтгүй байна. Төсөвлөөд тооцсон өртгийг байгууллагын удирдлага мэргэжлийн үүднээс тэр бүр хянаж чадахгүй учраас хувийн хэвшлийн байгууллагаар хянуулах буюу өөрийн барилгын инженерийн хийсэн төсвийн тооцоог төсвийн хүрээний мэдэгдэлд оруулан батлуулж байна. Тухайлбал: ГХЯ, ТЗҮААЭГ, ТЕГ, ТТХГ, МШХХТГ тооцоолсон төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар хянуулаагүй байна.

Дипломат төлөөлөгчдийн газрын байрны засварын зардал, өртгийг зарим ЭСЯ-д дутуу тооцсон байна. Тухайлбал: 2008 онд Анкара, Алмата дахь ЭСЯ-ны барилга барих 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн тооцоог ирүүлээгүй байхад төсөв баталж, санхүүжилтийг шилжүүлжээ. Мөн Нью-Йорк дахь байнгын төлөөлөгчийн газрын 403.2 сая төгрөгийн их засварын ажлын төсвийн тооцоог ирүүлээгүй байхад санхүүжилт хийсэн байна.

ТЗҮААЭГ-т 2008 оны төсвийн хүрээний мэдэгдэлд төсөвлөсөн 310.3 сая төгрөгийн засварын ажлын өртгийн тооцоо хийсэн баримт байхгүй, тоног төхөөрөмж худалдан авах 948.0 сая төгрөгийн төсвийн тооцоо дутуу байлаа.

Ихэнх байгууллагууд үнийн судалгааг бүрэн боловсруулаагүйгээс чанарын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж худалдан авч байна.

Төсөвт өртгийг бодитой тооцсон эсэхийг “Барилгын тухай” хуулийн 15.2-т “зураг, төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу мэргэжлийн экспертизээр хянуулсан байх шаардлагыг ТЕЗ-дад тавьдаг байна.

Төсөвт өртгийн үнэ ханшид өөрчлөлт орсон болон өртгийг үндэслэл муутай тооцсоноос гүйцэтгэлийн явцад нэмэгдэл хөрөнгө шаардагдаж, төсөвт хүндрэл учруулж байна. Тухайлбал: Завхан аймгийн ЗДТГ-ын контор, Тагнуулын хэлтсийн барилгуудын төсөвт өртгийг буруу тооцсоноос нэмэлт санхүүжилт авах болоод байна.

Ийнхүү хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг бодитой үндэслэлтэй тооцсон эсэхийг хянадаг үр нөлөөтэй тогтолцоо алга байна.

1.2. Хөрөнгө оруулалтын талаар улсын хэмжээнд нэгдсэн бодлого, төлөвлөлт дутагдалтайгаас санхүүгийн боломжийн хэмжээнд хүртээх байдлаар төлөвлөж байна

ТБУСТ хуулийн 7.1.2-т "ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон энэ хуулийн 5.2-т заасан төсвийн удирдлагын зарчимд нийцүүлэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсвийн төслийн жил бүрийн болон дунд хугацааны үндсэн үзүүлэлтийг боловсруулах" гэж заасныг ТЕЗ, СЯ мөрдөж ажиллаагүй байна.

УИХ-аар батлагдсан ЗГ мөрдөж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө алга байна. Харин УИХ-аар баталсан ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж байна. ТЕЗ-дад дунд хугацааны хөрөнгө оруулалтын тусгайлсан стратеги төлөвлөгөө алга байлаа.

СЯ хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нэгтгэхдээ ТЕЗ-дын саналыг харгалзан ач холбогдлоор нь эрэмблэн тусгадаг гэх боловч эрэмбэлсэн нарийвчилсан судалгаа байхгүй байна.

Харин зураг төсөвгүй барилга байгууламжийг төлөвлөгөөнд тусгахгүйн тулд 2008 оноос эхлэн зураг төсөл боловсруулах ажилд хөрөнгө төлөвлөн, түүнийг нь холбогдох ТЕЗ-д хэрэгжүүлж байна.

СЯ тухайн санхүүгийн жилд зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах тэргүүлэх ач холбогдол бүхий төслийн жагсаалтыг тусгайлан гаргаж, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамт холбогдох газар албан ёсоор хүргүүлээгүй, харин санхүүгийн эх үүсвэрийн хэмжээг л өгч байна.

СЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэс хөрөнгө оруулалтын цогц бодлого байхгүйгээс зөвхөн төлбөр тооцооны үүрэг гүйцэтгэж байгаа мэт байна.

СЯ Улсын төсвийн нийт эх үүсвэрийн боломжит хэмжээг макро түвшинд тооцоолон түүнээс тухайн жилийн хөрөнгө оруулалтын боломжит санхүүгийн эх үүсвэрийн

хэмжээг тодорхойлдог байна. Ингэхдээ өмнөх оны гүйцэтгэлээс бууруулахгүй байх боломжийг эрэлхийлдэг.

Гадаадын зээл болон хандив тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн арга хэмжээ төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээтэй давхардаж байгаа эсэхэд СЯ-наас тавих хяналт хангалтгүй байна.

СЯ-нд орон нутгийн өмчийн хөрөнгөөр аймаг, орон нутгийн хэмжээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нарийвчилсан судалгаа, гүйцэтгэлийн талаарх мэдээлэл байхгүй байна.

Ийнхүү хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн уялдаа холбоог нэгтгэсэн стратеги бодлогогүй байна.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн байна

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд 100.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг зайлшгүй шаардлагатай бус гэж үзэн хойшлуулсан байхад БСШУС, ЗГХЭГ, БХС, Сангийн сайдын нийт 12.7 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг 6.1 тэрбум төгрөгөөр, МУХС-гийн хөрөнгө оруулалтаас БСШУС-ын төсөл, арга хэмжээг 10.6 тэрбум төгрөгөөр нэмж тодотголоор баталжээ.

Аудитын явцад эдгээр салбарт ямар учраас нэмэлт санхүүжилт хийсэн талаар нэмэлт тооцоо материал, шаардлага хангасан баримт материал байхгүй байна.

Бүлэг 2. Худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байна

ТЕЗ-дын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2008 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийсэн нийт худалдан авалтын 86 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 6 хувийг харьцуулалтын аргаар, 3 хувийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар, 5 хувийг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлсэн байна.

2.1. Тендер зарлах хүртэлх бэлтгэл үе шатны ажлыг зохих хууль, журмын дагуу хийхгүй байна

Аудитад хамрагдсан зарим байгууллагууд ТБОНӨХБАҮХАТХ /цаашид хууль гэх/-ийн дагуу тендерийн урилга, үр дүнг цахим хуудас, өдөр тутмын сонин зэрэг мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж байх учиртай ч энэ ажил бүрэн хийгдэхгүй, ХАА-ны аргыг буруу сонгосноос ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчим алдагдаж байна. Тухайлбал:

- ТEG-аас тавилга, тоног төхөөрөмж худалдан авахаар зарласан 2 тендер шалгаруулалтын www.e-procurement вэб-сайтад нэвтрэх эрх аваагүй, урилгыг нийтлээгүй, хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар гүйцэтгэгчийг сонгосон, мөн ТТХГ уг вэб-сайтад нэвтрэх эрхээ аваагүй, 4 тендерийн урилгыг нийтлээгүй байна.
- СЯ ХАА-ны 2008 оны төлөвлөгөөнд харъяа байгууллагуудын төлөвлөгөө нэгтгэгдээгүй байна. Татварын ерөнхий газар босго үнээс давсан тендер шалгаруулалтын урилгыг нийтлээгүй байна.
- ЦЭК, УМХГ, УИХ-ын Тамгын газар, Тэргүүн шадар сайдын багц, ҮХЦ, ХАА-ны ерөнхий төлөвлөгөөг мэдээлдэггүй, цахим хуудсанд мэдээлэх төсөвт өртөгтэй ХАА-г тогтмол зарлан мэдээлээгүй, нөхөн оруулдаг, ЗГХЭГ эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний талаарх мэдээлэл дутуу байна.

Хуулийн 47, 47.5-д заасны дагуу үнэлгээний хорооны гишүүдийн ХАА-гаар мэргэшсэн байх шаардлага хангагдаагүй байх, тендерийн бичиг баримтаар шаардсан материалыг бүрэн ирүүлсэн байх шаардлагад нийцсэн тендер зарим тохиолдолд ирээгүй гэсэн үндэслэлээр тендер шалгаруулалт хүчингүй болох, үнэлгээг дутуу хийх, түүнчлэн захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн бичиг баримтад заасан журмын дагуу ашиглахгүй байх явдал түгээмэл байна.

- ТEG-т шаардлагатай тоног төхөөрөмж манай улсад үйлдвэрлэдэггүй тул үнэлгээний хорооны санал тэр бүр хэрэгждэггүй, гүйцэтгэгч сонгох боломжгүй гэсэн тайлбарыг ихэнх ХАА-нд хамруулан зарим худалдан авалтыг босго үнэ хүрээгүй үндэслэлээр ХТШ, ШГ-ний аргаар зохион байгуулсан байна.
- ОБЕГ-аас ТББ-т шаардах техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ хуулийн 11.1.2-т заасны дагуу олон улсын стандарт буюу үндэсний стандарт, техникийн шаардлагад үндэслэн хийгээгүйгээс тендер шалгаруулалтын үнэлгээг хийхэд хүндрэл гарсан. 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Галын автомеханик шатны автомашин, Хорт хий утаанаас хамгаалах албаны болон утаа зайлуулагч автомашиныг нийлүүлэх гүйцэтгэгч шалгараагүй байна.
- ЗГХЭГ-ын эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнд ХАА-ны ямар арга хэрэглэсэн нь тодорхойгүй байна.
- Чөлөөт бүсийн ХАА-г ҮХЯ хамаарч байсан ба тендерийн үйл ажиллагааг журмын дагуу явуулахад ХАА-г удаашруулсан явдал гарсан, үнэлгээний хороог зохих ёсоор байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулаагүйгээс ХАА-ны ач холбогдлыг бууруулсан байна. Тухайлбал: “Замын-Үүд” ЭЗЧБ-д зохион байгуулагдах хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд үнэлгээний

хороог ҮХЯ-ны ТНБД-ын 2008 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 8 дугаар тушаалаар байгуулсан ч, ҮХЯ-ны ТНБД-ын 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 117 дугаар тушаалаар бүрэлдэхүүнийг өөрчилжээ. Бүрэлдэхүүн өөрчлөгдөж “Мастер төлөвлөгөө боловсруулах, зөвлөх үйлчилгээ”-ний тендер шалгаруулалтыг хүчингүй болгосон, мөн ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй байна.

Тендер шалгаруулалтыг зохион байгуулахад хугацаа алдах явдал арилахгүй байна. Үүнд объектив, субъектив олон шалтгаан байгаагийн нэг нь тендер зарлаж, шалгаруулахад тодорхой хугацаа зайлшгүй шаардагддаг явдал юм. Хугацаа алдах нь сөрөг үр дагавар учруулж байна. Тухайлбал, жилийн дөрвөн улиралтай манай орны хавар, зун, намрын урин дулаан цагт барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх нь тохиромжтой байдаг. Өвлийн хүйтэнд ажил чанар, стандартын шаардлага хангахгүй бөгөөд дахин засварлах зэргээр нэмэлт зардал шаардах явдал тохиолддог. Түүнчлэн тухайн жилд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын арга хэмжээ ондоо бүрэн хэрэгжиж амжилгүй тасрах тохиолдол нийтлэг шинжтэй байна.

Үнэлгээний хороог цаг хугацаанд нь байгуулаагүй, зарим үнэлгээний хороо үр дүнтэй ажиллаагүй байна.

Мөн чадварын мэдээлэл ирүүлэх маягыг жишиг баримт бичгийн дагуу хийгээгүй, тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, тендер оролцогчдод өгөх зөвлөмжийг иж бүрэн боловсруулаагүй тохиолдол гарсан байна.

Зарим газруудад тендер зарлагдсан ч оролцогч ирээгүй, цөөн тооны оролцогч ирсэн, тендер зарлах үнийн дүнг жижиглэн харьцуулалтын аргыг хэрэглэсэн байна.

Судалгаанаас үзэхэд зарим захиалагч босго үнээс давсан үнэ бүхий бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг зөвшөөрөл авалгүй зарласан, эсвэл тендер шалгаруулалтыг зарлах зөвшөөрөл авсан боловч уг тендер шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийг ирүүлж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахын өмнө зөвшөөрөл аваагүй зөрчил байсаар байна.¹

Үнэлгээний хороодод тухайн салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл оролцох эрх нээлттэй боловч оролцоогүй байна.

2.2. Гүйцэтгэгч шалгаруулах ажиллагаанд үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримталсан гэх үндэслэл муутай байна

Шадар сайдын багцад Архангай аймгийн бүс нутгийн хөгжлийг дэмжих, мөн олон салбар арга хэмжээний хүрээнд хөдөө орон нутагт шинээр баригдах барилга, байгууламжийн ТЭЗҮ боловсруулах нилээд хэмжээний хөрөнгө оруулалтын төсөв батлагджээ. Энэхүү хөрөнгө оруулалтын гүйцэтгэгчийг сонгох ажиллагааг хуулийн дагуу явуулсан эсэхэд хяналт тавьсан гэх ямар нэг баримт материал байхгүй бөгөөд Шадар сайдын ажлын алба зөвхөн зөвшөөрөгдсөн хөрөнгийг дамжуулах л үүрэг хүлээж байна.

¹ Эх үүсвэр: Сангийн яамны ХААБЗГ-ын 2008 оны тайлан

МШХХТГ-ын зөвшөөрөл авсан “Сумдын дамжуулах байгууламжийн шилэн кабелийн суурилуулалтын ажил”-ын ТН-01/08 төслийн ТББ алдаатай боловсруулснаас 361.0 сая төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна.

ТЕГ-т өрсөлдөгчийг шалгаруулдаггүй тул үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг хэрэгжүүлж сонгох боломж муутай, үнийн саналыг 2 тал нягтлан үзсэнээр тоо ширхэгээс шалтгаалан үнэ бууруулах зарчмыг баримталдаг байна. УМХГ-ын ТТ08/04, ТТ08/05 тендерийг зохион байгуулахдаа үнэлгээний хорооны гишүүдэд бичиг баримтын боловсруулалт, урамшуулалт цалинг хэмнэлтээс 780.0 мянган төгрөгийг олгосон нь эрх зүйн актаар хүлээн зөвшөөрөгдөөгүй, хуулийн 50 дугаар зүйл “Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагчийн үүрэг”-ийг зөрчсөн байна.

ОБЕГ тендерийн хэмнэлтээс 42.7 сая төгрөгийн барааг харьцуулалтын аргаар худалдан авчээ.

2.3. ХАА-ны тайланг хугацаанд нь бүрэн тайлагнахгүй байна

2008 оны ХАА-ны ерөнхий төлөвлөгөөг ГХЯ, Сүхбаатар, Хөвсгөл, Сэлэнгэ, Архангай, Баянхонгор, Хэнтий аймаг хоцроосон, Шадар сайдын багц ирүүлээгүй байна.

Ерөнхий сайдын багцад хамаарах байгууллагууд ХАА-ны 2008 оны төлөвлөгөөг холбогдох газар хүргүүлээгүй байна.

Тэргүүн шадар сайдын багцад хамаарч буй СХЗҮТ, ШБӨХЗГазар, “Чойр” ЧБ 2008 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай ерөнхий тайланг холбогдох маягтын дагуу гаргаагүй, ХАА-г зохих журмын дагуу тайлагнаагүй байна.

ТЕЗ-даас харъяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар болон худалдан авах ажиллагааны зааварчилгаа, аргачлалаар хангаж, хяналт тавьж ажилласан байдлын тухай бичмэл тайланд тусгахаар зааварчилсан боловч энэ тухай мэдээлэл бүрэн хийгдэхгүй байна.

СЯ-ны ХААБГ-аас худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг журамд заасан шалгуур үзүүлэлт, харгалзах оноогоор дүгнэсэн. ТЕЗ нарт хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, холбогдох хяналтыг хэрэгжүүлэхийг Сангийн сайдын албан бичгээр хүргүүлж байгаа хэдий ч тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж

Төсвийн ерөнхийлөн захирагч	Үнэлгээ
Сангийн Сайд	64
Гадаад харилцааны сайд	46
Үндэсний статистикийн газрын дарга	70
Шадар сайд	0
Тэргүүн Шадар сайд	43
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	75
Монгол Улсын Их Хурлын дарга	85
Монгол Улсын Ерөнхий сайд	78
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	60
Төрийн албаны зөвлөлийн дарга	92
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	60
Хүний эрхийн Үндэсний комиссын дарга	76
Үндсэн хуулийн цэц	85
Төрийн өмчийн хороо /УУГГазрууд/	36
Авлигатай тэмцэх газрын дарга	62

болгон хадгалж байгаа ч хуулийн заалтын дагуу иж бүрдлийг бүрэн хангаж чадахгүй байгаа дутагдал нийтлэг байна. Тухайлбал: Нээлттэй тендер шалгаруулалтаас гадна өөр арга хэрэглэсэн тохиолдолд шалтгааныг иж бүрэн тайлагнаж бүртгээгүй, архивын нэгжийн анхан шатны шаардлагыг хангаагүй, үнэлгээний дүгнэлт иж бүрэн бус байдал УМХГ, ТТХГ, ТЕГ, МШХХТГ-уудад ажиглагдаж байна.

Мөн ирсэн бүх тендерийн материалыг хадгалаагүй, зөвхөн шалгарсан тендерийг хадгалсан, эсвэл гэрээ байгуулах хүртэлх материалыг хадгалсан байдал нийтлэг байна.

Худалдан авалтын үйл ажиллагааны үр дүнг илүү нээлттэй мэдээлэх шаардлагатай байна.

СЯ-ны ХААБГ хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, үнэлгээний хороо байгуулаагүй, батлагдсан төсөвт өртөгт багтааж тендер шалгаруулалт явуулаагүй, тендерийн баримт бичгийг хангалтгүй боловсруулсан, үнэлгээний аргачлалыг мөрдөөгүй зэрэг зөрчил гаргасан албан тушаалтнуудад хуулийн дагуу арга хэмжээ авах саналаа холбогдох газарт хүргүүлж байх, түүнчлэн:

- Хуулийн 49.8-д заасны дагуу ЗГ-ын жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны үр дүнг тусгуулах;
- Тендерт оролцох эрхээ хасуулсан этгээдийн бүртгэл хөтлөх, хяналт тавих, нийтэд мэдээлэх;
- ТЕЗ нар ХАА-ны талаар тендерт оролцогчдыг цахим мэдээллээр хангаж байх үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бүлэг 3. Гэрээ зөрчсөн, биелүүлээгүй, бараа, ажил, үйлчилгээг хугацаандаа нийлүүлээгүй гүйцэтгэгч байгууллагуудад алданги, хариуцлага тооцохгүй байна

3.1. Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах үйл явцтай холбоотой эрх зүйн орчинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна

Гэрээний хугацаанд бараа, ажил, үйлчилгээг нийлүүлээгүй тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх үүрэг, нэмэлт нөхцлүүдийн талаарх заалт үгүйлэгдэж байна.

- *ОБЕГ: Зарим барилгын ажил цаг хугацаандаа нийлүүлэгдэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд хугацаа сунгах нэмэлт заалтуудыг оруулж өгөөгүй байна.*
- *ГХЯ: Гадаад оронд байгаа Элчин сайдын яамдын худалдан авалт, гэрээний биелэлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг хянах боломжгүй байна.*

3.2. Гэрээний гүйцэтгэлд ач холбогдол өгөхгүй байна

Хуулийн 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 4 дэх хэсгийг мөрдөж ажиллаагүй тохиолдол гарсан байна. Тухайлбал:

- *Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын конторын барилгын ажлыг гүйцэтгэгч "Койоттрейд" ХХК ажлын гүйцэтгэлийг төсөвт өртгөөр гарган захиалагчид хүргүүлсэн боловч аймгийн БЗА-аар баталгаажуулаагүй байна.*
- *Дархан-Уул аймгийн Орхон, Шарын гол сумдын ЗДТГ-ын конторын барилга засварын 50.0 сая төгрөгийн ажлыг тендер зарлалгүй гүйцэтгэгчийг сонгож, гүйцэтгэлийн явцад хяналт тавиагүйгээс чанарын шаардлага хангахгүй байхад ажлын болон улсын комисс хүлээн авсан актгүйгээр бүртгэлд тусгасан байна.*

Гэрээт ажлын явц, нийлүүлж байгаа бараа, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд хяналт сул тавьсан ба зарим хэсэгт хяналт тавиагүй тохиолдол нилээд гарсан байна.

Тухайлбал:

- *ГХЯ: Гэрээт ажлууд болон барилгын засвар, машин тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн боловч санхүүжилт удааширнаас зарим байгууллагууд гэрээний хугацааг хэтрүүлсэн байна.*
- *ЗГХЭГ: Тоног төхөөрөмжид түүвэрлэн тулган баталгаажуулалт хийхэд гүйцэтгэлийн тоо зөв боловч бүртгэлд 4.9 сая төгрөгөөр тусгахыг 4.5 сая төгрөгөөр бүртгэж, 306.0 мянган төгрөгийг зардалд тусгасан байна.*

Хуулийн 40.3.7 дахь заалтыг зөрчиж хуурамчаар ажлын гүйцэтгэл гаргасан байна. Тухайлбал:



ОБЕГ: ХУД-ийн гал унтраах 30 дугаар ангийн галын депогийн барилга, 4 машины гараж барих ажлыг "Хөхий Хан" ХХК 256.0 сая төгрөгийн төсвөөр гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Барилгын явц, чанар, хийц, гүйцэтгэлд тавих



захиалагчийн хяналт сулыг ашиглан тоосгоор өрөхийг блокоор өрсөн нь чанар, үнийн зөрүүний хувьд ялгаатай байгаа зөрчил илэрлээ. Аудитын явцад хуурамч гүйцэтгэл гарган 664.0 мянган төгрөг илүү авах явдлыг таслан зогсоож гүйцэтгэгч байгууллагаар төлүүлэхээр шийдвэрлэлээ.

- Баянхонгор аймгийн Онцгой байдлын алба “Ланд круизер-80” автомашин худалдан аваад орлогод авсан гэх боловч биет байдлаар алга байсан. Аудитын явцад Улаанбаатар хотоос автомашиныг авчруулж тулган баталгаажуулан зөрчлийг арилгасан байна.

3.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын гэрээний биелэлтэд хариуцлага тооцохгүй байна

Хуулийн 57.3-т "Тендерт оролцогч болон аливаа этгээд нь худалдан авах гэрээний үүргээ зөрчсөн, биелүүлээгүй, тендерт орохдоо илт худлаа мэдүүлсэн, авилгалын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон бол уг шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тендерт эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулна" гэж заасныг мөрдөн ажиллаагүй доорх байгууллагуудад алданги, хариуцлага тооцоогүй байна.

Тухайлбал:

- ОБЕГ-т бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх “Хөхий хан” ХХК-ийн хувьд гэрээг сунгаагүй, ашиглалтад оруулах хугацаанаас 27 хоног хэтэрсэн нь захиалагч болон гүйцэтгэгч тал хариуцлагагүй ажилласантай холбоотой байна.
- Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Баянцагаан, Баянговь сумдын ЗДТГ-ын их засварын ажлыг “Рашаант булаг” хоршоо, “Хашгоёо” ББНөхөрлөл, “МЦЭнх” ХХК-иар гүйцэтгүүлсэн боловч зураг төсвийн дагуу бус, чанаргүй хийсэн нь гүйцэтгэлд захиалагч тал хяналт тавиагүй байна.
- Тагнуулын хэлтсийн барилгын ажлыг “Баян Өндөр” ХХК-иар гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан ба гэрээнд заагдсан хугацаандаа дуусгаагүй байхад захиалагч тал тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Аудитын явцад дараахь байгууллагуудын гэрээний биелэлтийг гаргаж албан шаардлага өгөв. Үүнд:

- МХХТГ: Гэрээний дагуу кабель нийлүүлэх “Очир төв” ХХК-д 30.4 сая төгрөгийн,
- ОБЕГ: Гэрээний дагуу барилга байгууламжийг цаг хугацаандаа нийлүүлээгүй “Хөхий хан” ХХК-д 3.9 сая төгрөгийн,
- ЗГХЭГ: Барилга засвар болон тоног төхөөрөмж цаг хугацаандаа нийлүүлээгүй гэрээлсэн “Явуу Импекс” ХХК-д 0.9 сая, “108 суврага” ХХК-д 3.3 сая, “Си-Эйч-Си” ХХК-д 17.2 сая, “Сигма Монголиа” ХХК-д 6.1 сая, “Баткубик” ХХК-д 0.4 сая, “Хандок Элеватор” ХХК-д 6.7 сая, “Ука Сан” ХХК-д 0.7 сая төгрөгийн,
- УМХГ: Гэрээний дагуу тоног төхөөрөмж нийлүүлэх “Цэцүүх трейд” ХХК-д 1.4 сая төгрөгийн алданги ба хариуцлага тус тус тооцоогүй байна.

Бүлэг 4. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны удирдлага, санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо оновчтой, үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулагдаж чадахгүй байна

Оршил

Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгө оруулалтын 2008 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг авч үзэхэд гүйцэтгэлээр 465.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай гарч байна. Энэ нь 2006-2007 оны гүйцэтгэлээс 3.5-1.3 дахин их байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийг 2008 онд 1059 төсөл, арга хэмжээнд зарцуулсан нь 2007 оныхоос 86 төсөл, арга хэмжээгээр бага байхад МУХС-гаас 2008 онд хөрөнгө оруулалтын 1571 төсөл, арга хэмжээнд зарцуулсан нь 2007 оныхоос 314 төсөл, арга хэмжээгээр илүү байна.

Бусад төрийн байгууллагуудын хувьд 2008 онд улсын төсөв, МУХС-гийн хөрөнгө оруулалтаар 73.0 сая, орон нутгийн төсвөөс 199.5 сая, гадаадын тусламжаар 528,5 сая, өөрийн хөрөнгөөр 882.8 сая, бусад эх үүсвэрээр 3090.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. /Судалгаа 1-3-ыг үзнэ үү/

4.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх үйл ажиллагааг өөрчлөх шаардлагатай болжээ

Монгол Улсын 2008 оны төсвийн тухай, МУХС-гийн 2008 оны төсвийн тухай хуулиудыг үндэслэн Сангийн сайдын 2008 оны 29, 50, 62 дугаар тушаалаар санхүүжилтийн хуваарийг батлан хэрэгжүүлсэн байна.

СЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтэс Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүжилтийн эрхийг нээж, Төрийн сангийн газар санхүүжүүлж иржээ.

ТЕЗ бүрээр санхүүжилтийн эрх нээлтийг нэгтгэн бүртгэх програмгүйгээс нэгдсэн судалгааг гаргадаггүй бөгөөд аудитаар зарим ТЕЗ-дын эрх нээсэн дүнг санхүүжүүлсэн дүнтэй сар бүрээр тулган баталгаажуулах боломжгүй байлаа.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай тайлан мэдээ, программ хангамж дутагдаж байна.

Сангийн яам улсын төсөв, МУХС-гаас хөрөнгө оруулалтад 2008 оны 4 дүгээр улиралд 226.7 тэрбум төгрөг, 12 дугаар сард 131.5 тэрбум төгрөг, 2008 оны 12 дугаар сарын 20-ноос хойш 11,4 тэрбум төгрөгийн 178 гүйлгээ хийсэн байна. Өөрөөр хэлбэл нийт хөрөнгө оруулалтын 48.7 хувийг 2008 оны 4 дүгээр улиралд, 28.3 хувийг 12 дугаар сард санхүүжүүлсэн байна.

Аудитын явцад зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийн эрх нээлт, санхүүжилт, захиалагчаас гүйцэтгэгчид санхүүжүүлсэн байдлыг МХЕГ, ТЕГ, ЗГХЭГ, МШХХТГ-т тулган баталгаажуулахад Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.14-д “СЯ-ны Төсвийн бодлого, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтэс энэхүү журмын 3.4-т заасан материалыг бүрэн хүлээн авсанаас хойш ажлын 2 өдрийн дотор хянаж эрх нээнэ.

Төрийн сангийн газар нь нээгдсэн эрхийн дагуу холбогдох хууль, журамд нийцүүлэн ажлын 2 хоногт багтаан тухайн төслийг санхүүжүүлнэ”, 3.15-т “Захилагч байгууллага өөрийн дансанд санхүүжилт орсноос хойш 2 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад санхүүжилт олгоно.

Хэрэв захиалагч шаардсан хугацаанд гүйцэтгэгчид хөрөнгийг шилжүүлэхгүй бол хөрөнгийг Төрийн сангийн дансанд татаж, захилагчийн саналыг үндэслэн гүйцэтгэгчийн дансанд шууд шилжүүлнэ” гэсэн заалтууд хэрэгжээгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд нийт 241,4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлыг бүрэн хийгээгүй, барааг нийлүүлээгүй зөрчил аудитаар илэрлээ.

Тухайлбал:

- Дархан-Уул аймгийн орон сууцны гадна тохижилтын 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын *ааеё аздүй аóóñäääé* ааёбаа гүйцэтгээч байгууллагыг бүрэн санхүүжүүлсэн ба орон сууцны *аааí ä ò î ðеæеёò î ä í өеёззёñуî ò î аеí î î , ñаdаа-óоä ÷-аí аддйí ø ааддææааä аздүй õаí ааааäé, ñóóддөёóöæааäé* 10 ш тоглоом, бариагүй 8 ш саравч байна.
- Цөмийн энергийн комисс 2008 оны 10 дугаар сарын 17-нд 32.6 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний валютаар “PTWG asia Pasific” LTD компаниас авах тоног төхөөрөмжийн үнийг шилжүүлсэн боловч ондоо багтаан аваагүй байна.
- Өвөрхангай аймгийн Уянга сумын ЗДТГ-ын барилгын угсралтын ажил гүйцэтгэх “Цагаанбургалтай” ХХК-тай байгуулсан гэрээнд санхүүжилт авах хугацаа, графикийг зааж өгөөгүйгээс санхүүжилт оройтож, барилгын ажлын явц удааширч, *ì äò äдæäë, ò ýúâддөéí çí èéí ç° ðçç* 34.6 *ñàý ò ° äдөгөөр нэмэгджээ. Аймгийн ИТХТ-èéí ò î äð î î èí î ð î ðí í í óò äèéí °ì ÷-èéí ñáí äààñ* 2007,2008 *í í ä* 34,6 *ñàý ò ° äð° äèéí í ýè ò ñáí õççææèò î èäí ñí í áäéí ä.*

Ийнхүү бүрэн хийгдээгүй, нийлүүлээгүй бараа, ажил үйлчилгээнд санхүүжилт олгосон байна.

Тайлант оны эцэст зарим ТЕЗ зарцуулаагүй үлдэгдлээ буцаан төвлөрүүлэхгүйн тулд гүйцэтгэгчийн болон БЗА-ны дансанд авч үлдсэн байна. Тухайлбал:

- ЗГХЭГ оны эцэст 633.1 сая төгрөгийг БЗА-ны Хадгаламжийн тооцооны 9-р төвийн дансанд, МШХХТГ 40.0 сая төгрөгийг “МХС” ХХК-ны дансанд, ТТХГ 483.7 сая төгрөгийг БЗА-ны дансанд шилжүүлсэн байна.
- ТТХГ 183.7 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг баталгаажуулсан акт үйлдээгүй байна. Мөн 2007 онд “Одкон холдин” ХХК-ийн 300.0 сая төгрөгийг БЗА-д шилжүүлэн өгөөгүй бөгөөд 2008 онд 11 дүгээр сарын 17-нд уг барилгыг улсын комисс хүлээн авчээ. Гэтэл 2008 оны 3 дугаар сарын 5-нд 279.4 сая төгрөгийг өгч үлдэх 63.7 сая төгрөгийг БЗА-ны харилцах дансанд барьцаа болгон авч үлдсэн байна.

ТЕЗ, төсөвт байгууллагууд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүр гаргаж өгч хэвшээгүй, ажил хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй байна.

Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 1.5 "Улсын болон орон нутгийн төсөв, МУХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалт зөрчигдөж байна.

- *Монгол Улсын 2008 нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр Цөмийн энергийн комиссийн барилгын хөрөнгө оруулалтыг 499.9 сая төгрөгөөр тайлагнасан байна. Гэтэл барилгад 196.5 сая, их засварт 89.8 сая, тоног төхөөрөмжид 213.6 сая төгрөг зарцуулсан байна.*

Эх үүсвэрийг хооронд нь шилжүүлэн зарцуулсан боловч гүйцэтгэлийн тайланг бодит байдлаар гаргаагүй байна.

Дараахь 4,2 тэрбум төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Тухайлбал:

- *ТЕГ Завхан аймгийн Тагнуулын хэлтсийн барилгад 50.0 сая, Замын-Үүдийн барилгад 364.9 сая төгрөг, нийт 414.9 сая төгрөгийг тоног төхөөрөмж авах хөрөнгөөс барилгын хөрөнгө оруулалтад зарцуулснаа тоног төхөөрөмжийн гүйцэтгэлээр тайлагнажээ.*
- *Баянхонгор аймгийн Баян-Овоо, Өлзийт сумдын төсвийн байгууллагад тоног төхөөрөмж худалдан авч өгөхөөр төлөвлөсөн атлаа тоног төхөөрөмжийг авч өгөлгүй Баянхонгор сумын ЗДТГ-т 8 багийн засаг даргад автомашин авахад 36.7 сая төгрөг, аймгийн Хөгжимт драмын театрт төгөлдөр хуур хөгжим авахад 2.0 сая төгрөг, нийт 38.7 сая төгрөгийг зориулалтын бус зүйлд зарцуулжээ.*

Баянхонгор аймгийн Өлзийт сумын ЗДТГ-т автомашин авахад улсын төсвөөс 10.0 сая төгрөг өгсөн байна. Автомашиныг 14.9 сая төгрөгөөр хувь хүнээс худалдан авч 4.9 сая төгрөг илүү зарцуулжээ. Үүний 1.5 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын дэргэдэх хөрөнгө оруулалтын сангаас, 3.4 сая төгрөгийг орон нутгийн орлогын эх үүсвэрээс тус тус гаргасан байна.

Ийнхүү хөрөнгө оруулалтын арга хэмжээнд санхүүжилтийн эх үүсвэрүүдийг давхардуулан зарцуулжээ.

Аудитад хамрагдсан байгууллагуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 32.9 тэрбум төгрөгийн автомашин, техник хэрэгсэл, тавилга бэлтгэсэн байна. Гэтэл урсгал санхүүжилтээс 885.8 сая төгрөгийг мөн адил зарцуулжээ. Үүнээс үзэхэд урсгал зардлаар хөрөнгө оруулалтын шинж чанартай хөрөнгө бэлтгэж байна. Гэвч төсвийн гүйцэтгэлд эд хогшил бэлтгэх зардлыг хэтрүүлээгүй харагдуулахын тулд худлаа тайлагнаж байна. Тухайлбал:

- *"Алтанбулаг" ЧБ өөрийн орлогоос 273.7 сая, урсгал төсвөөс 12.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.*

Зарим хөрөнгийг хөрөнгө оруулалт болон урсгал санхүүжилтээр адилхан бэлтгэж байна.

4.2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт оновчтой бус байна

төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч “Эрчим зураг төсөл” ХХК-д шилжүүлсэн боловч одоо хүртэл зураг төсвөө аваагүй, авлагаар бүртгээгүй байна.

Орон нутгийн төсөв, хандив тусламжийн хөрөнгөөр бэлтгэж буй хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны талаар нэгтгэн хянан удирдах, зохион байгуулах эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай байна.

Гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн талаархи асуудлыг СЯ-нд хариуцсан газар байдаг боловч тэдгээр төслүүдээс хийгдэж буй хөрөнгө оруулалтын шинж чанартай үйл ажиллагааг хянан удирдаж, зохион байгуулах эрх зүйн зохицуулалтгүй байна.

Төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтээр эд хогшил, техник хэрэгсэл бэлтгэх үйл ажиллагааг зааглах асуудлыг СЯ судалж шийдвэрлэх шаардлагатай байна.

Өөрийн орлого, төсвийн урсгал зардлаас ямар хэмжээний хөрөнгө худалдан авч болохыг тодорхой зааж өгөөгүйгээс эх үүсвэр бүрээр хөрөнгийг бэлтгэж, нэгдсэн хяналт, зохион байгуулалтад орохгүй байна. Тухайлбал: ТТХГ хандивын хөрөнгөөр 6.2 сая, өөрийн хөрөнгөөр 4.7 сая, урсгал санхүүжилтээр 2.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бэлтгэсэн байна. ТЕГ хандивын хөрөнгөөр 244.9 сая, урсгал санхүүжилтээс 62.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө авчээ.

4.3. Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явцад тавих дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо дутагдаж байна

2008 онд МУХС, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас нийт 62.1 тэрбум төгрөгийг аймаг, нийслэлд санхүүжүүлсэн байна.

Холбогдох хуулийн дагуу эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ерөнхий захиалагч хяналт тавиагүйгээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд тайлант онд багтан ашиглалтад орохгүй байх, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах, нэмэлт хөрөнгийг бусад эх үүсвэрээс гаргах гэх мэт зөрчил дутагдал гарч байна. Тухайлбал: ЗГХЭГ-аас 4176.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг орон нутагт шилжүүлснээс Баянхонгор, Дорнод, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий аймгуудын ЗДТГ-ын конторын барилга, их засварын ажилд хяналт муу тавигдсан дутагдал илэрчээ.


- Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын ЗДТГ-ын барилгын их засварт орон нутгийн төсвөөс 15.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр “Хонгор буурал” ХХК-д 14.8 сая төгрөг олгосон байна. Их засварын ажлыг газар дээр нь очиж танилцахад чанаргүй хийгджээ. Гэтэл улсын комисс их засварын ажил чанартай хийгдсэн гэж үзэн акт үйлдэн хүлээн авсан байна.
- Төв аймагт гэр нийлүүлэх “Богд-Өргөө” ХХК гэрээт хугацаанаас 5 сар 18 хоног хэтрүүлэн, чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлсэн байна.

Заддёл ааеёоёёааа оо оо í ꞑ í оооёаёооааò í ёā āāñí í оо оо í æéāÓÈÕ-û í æø ç¿ өөрөөсөө өгсөн мэтээр ойлгож, бүртгэлд тусгаагүйгээс гадí à, ° í ä° ð çí ýóýé, ÷àí àòû í ø ààòāèàāā òàí āāōā;é оо оо í ꞑ í еее ç;çéýò í ° оо° è á çòāýæ ò° ñāèéí оо оо í æéā çò àø èāç;é, çòýéāýí çàòòóóèàò ýāāāè āāòñāàò áàéí à. Тухайлбал:


ТӨХ 2007 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр эхний үлдэгдлийг програмд оруулсан байна. 2008 онд хөрөнгийн нэмэгдсэн, хасагдсан мэдээллийг оруулаагүй байна. Ийнхүү хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, санхүүгийн үйл ажиллагааг зохих стандарт, журмын дагуу хөтлөн явуулаагүй байна.

Улс, орон нутгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцож, холбогдох арга хэмжээ авч чадахгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудад хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох аргачлал, эрхийн актгүйгээс хөрөнгө оруулалтын үр өгөөжийн тооцоо, судалгаа хийгдээгүй байна.



ЗГ-ын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг ДНБ-д эзлэх хувийн жингээр авч үзвэл 2001 онд 22.9 хувь байснаас хойш 2005 он хүртэл буурч байсан ба 2006 оноос 4.1-6.9 хувь хүртэл өсч байсан байна. 2008 онд ДНБ-д 15.6 хувийг эзэлж



байна. Аймаг, нийслэлийн хүн амтай 2008 оны улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтыг харьцуулахад 1 хүнд 173.0 мянган төгрөг ногдож байгаа ба 2007 оныхоос 34.0 мянган төгрөг буюу 24.5 хувиар нэмэгдсэн байна. Дээрх судалгаанд Төвийн бүс, Зүүн бүс, Баруун бүс, Хангайн бүсээр бүсчлэн 2007, 2008 оны байдлаар авч үзэхэд Баруун бүсэд хөрөнгө оруулалт өндөр байна.

Нийт аймгуудын нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос буурсан байна. Гэвч нэг хүнд ногдох хөрөнгө оруулалтын хэмжээ хамгийн өндөр буюу Булган аймагт 203.8 мянган, хамгийн бага буюу Өвөрхангай аймагт 46.9 мянган төгрөг байна.

Нийслэлийн хувьд 2007 онд 86.6 мянган төгрөг байсан бол 2008 онд 181.6 мянган төгрөг буюу 47.7 хувиар өсчээ.

Хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байхад захиалагч байгууллага хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцож судалгаа хийдэггүй, ядуурал яаж буурсан, төрийн үйлчилгээ хэрхэн сайжирсан гэх мэт хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөний талаар аудитад хамрагдсан байгууллагууд судалгаа, тооцоолол хийгээгүй байна.

Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг ДНБ-ийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр² тооцон гаргахад дараахь байдалтай байна.



Графикаас харахад 2008 оны байдлаар манай улсын хөрөнгө оруулалтын үр өгөөжийн үзүүлэлт нь бусад улсуудын дундаж үзүүлэлтээс 3 дахин бага байна. Тухайлбал: Хөрөнгө оруулалтын үр өгөөжийн түвшин 2007 оны байдлаар ОХУ-д 2.8, БНХАУ-д 4.1, Зүүн өмнөд азийн орнуудад 4.8 байжээ.

